



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/53

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн тавдугаар хуралдааны 5/07 дугаар төсөв батлах тухай тогтоолын 5 дугаар хавсралтын 5.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хот тохижилтын үйл ажиллагаа эрхлэгч “Шинэ Ховд-Жаргалант ТҮК” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын цалин болон үйл ажиллагааны зардалд 262 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг аймгийн Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.9 дэх заалтаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

4. “Шинэ Ховд-Жаргалант ТҮК” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын цалин болон үйл ажиллагаанд зарцуулах зардлыг хавсралтаар баталсугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 0290

D/Zah-A/53-Bo

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дугаар сарын 27-ны өдрийн
А/53 дугаар захирамжийн хавсралт



“ШИНЭ ХОВД - ЖАРГАЛАНТ ТҮК” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЦАЛИН

			/төгрөгөөр/
д/д	Зардлын нэр	Нэг бүр	Нийт дүн
1	Цалин	21,833,333*12сар	262,000,000
Нийт зардал			262,000,000

-оОо-